
Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

**НЭГ. Товч танилцуулга[2]**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа 7 байгууллага тус бүр Ёс зүйн дэд хороо байгуулсан.




**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилго, 9 зорилт, 35 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
Гүйцэтгэлийг авч үзвэл:

---


[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үг дүнг нэгтгэн ирүүлнэ.
[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.





2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Байгууллагын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн албан хаагч аян"-ыг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн энэхүү аяныг харьяа байгууллага, орон нутгийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж ажиллах чиглэлийг Харьяа байгууллага, аймгийн ХХААГ, МЭГ-н удирдлагад Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/981 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Томилох эрх бүхий албан тушаалтан болон удирдах албан тушаалтнуудад зориулсан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлах соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан.





2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилго, 9 зорилт, 35 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн. Онцлох ажлуудыг авч үзвэл:

1. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох судалгааны асуумж бэлтгэн, судалгааг авах, мэдээллийг нэгтгэн гаргасан.
2. Албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн маягт бэлтгэсэн.
3. "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн албан хаагч" аяныг санаачлан хэрэгжүүлсэн.
4. Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, байгууллагын нээлттэй соёлыг хэвшүүлэх, дагалдуулах /менторшип/ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
5. Иргэд, олон нийтэд хүргэж буй яамны үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааны асуумж бэлтгэн QR код үүсгэн яамны угтах хэсэгт байршуулан, судалгааг жилийн турш авч байна.
6. Шинээр болон шилжин томилогдсон албан хаагчдад зориулсан "Чиглүүлэх сургалт"-ыг 2025 онд 2 удаа зохион байгуулсан.
7. Ёс зүйн хариуцлага хүлээсэн эсхүл сахилгын шийтгэл авсан 2 төрийн албан хаагчийг "Сургагч багш"-ийн ганцаарчилсан сургалтад хамруулсан.
8. Байгууллагын албан хаагчдад зориулсан ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж зааврааар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлэх зорилгоор "Албан хаагчдаа сонсох цаг"-г бий болгосон.
9. Хүнс, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа 7 байгууллагын Ёс зүйн дэд хороодод 2025 онд нийт 11 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд өргөдөл, гомдлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
|---|---|
| 1. Шинээр санаачлан 2.3 дахь хүснэгтэд дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.<br>2. 2026 онд "Сахилга хариуцлагыг сайжруулах жил" болгон зарлахаар Сайдын тушаалыг батлуулсан. | Албан хаагчдын зөөлөн ур чадвар, ёс зүйн хариуцлагыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудаас сургалт авах санхүүжилт байхгүй.<br>Үүнээс хамааран дотоод нөөц боломж дээр тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байна. |
| Санал: | |
| Ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан тусгайлсан сургалт, чиглүүлгийн хөтөлбөр гарган, сургалтыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, чадавхжуулах саналтай байна. | |

**Шалгах хэсэг:**

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан

| | | |
|---|---|---|
| ТНБД | | Т.ЖАМБАЛЦЭРЭН |
| /Албан тушаал/ | /Гарын үсэг/ | /Гарын үсгийн тайлал/ |

Ёс зүйн дэд хорооны дарга

| | | |
|---|---|---|
| БТГ-ЫН ДАРГА | | Ц.БОЛОРЧУЛУУН |
| /Албан тушаал/ | /Гарын үсэг/ | /Гарын үсгийн тайлал/ |

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

| | | |
|---|---|---|
| ТЗУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ | | Ч.ДОЛГОРСҮРЭН |
| /Албан тушаал/ | /Гарын үсэг/ | /Гарын үсгийн тайлал/ |

Огноо: ..... оны ..... сарын .....

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"**

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо[1] | Хувийн жин[2] |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ) | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4] | | 1 | 1 | 100 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5] | | 1 | 0.5 | 50 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6] | 0,5 | 0.5 | 100 |
| | | | Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7] | 0,5 | 0.5 | 100 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8] | 0,5 | 0.5 | 100 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9] | 0,5 | 0.5 | 100 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | 3.5 | 87.5 |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)* | | 1 | 1 | 100 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11] | | 1 | 1 | 100 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12] | | 1 | 1 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Хэсгийн оноо** | | | **3** | 3 | 100 |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ) | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13] | 1 | 1 | 100 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)* | 1 | 1 | 100 |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15] | 1 | 1 | 100 |
| **Хэсгийн оноо** | | | **3** | 3 | 100 |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | **10** | **9.5** | **98.61** |

БАТЛАВ.
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Ц.БОЛОРЧУЛУУН

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны.01...сарын.15.....-ны өдөр

| № | Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.** | | | | | | |
| 1 | 1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. | Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох судалгааны асуумж бэлтгэн, судалгааг авах, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх; | Дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлангийн тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 2 | | Албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн маягт бэлтгэн, бүртгэлжүүлэх. | Маягтын тоо; | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 3 | 1.2.Ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог хөгжүүлнэ. | Байгууллагын үнэт зүйлийг тодорхойлох асуумжийг бэлтгэн, нийт албан хаагчдаас судалгаа авах, үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулах; | Судалгааны тайлангийн тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 4 | | "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн албан хаагч" аяныг санаачлан хэрэгжүүлэх; | Аяныг хэрэгжүүлэх батлагдсан удирдамж, | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөний тоо | | | |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх. | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | 0 (Шинээр) | 4-с доошгүй | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 6 | 1.3.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг төлөвшүүлнэ. | Томилох эрх бүхий албан тушаалтан болон удирдах албан тушаалтнуудад зориулсан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлах соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | Сургалтын тоо | 0 (Шинээр) | 2-с доошгүй | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 7 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, байгууллагын нээлттэй соёлыг хэвшүүлэх, дагалдуулах /менторшип/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх; | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх батлагдсан удирдамж, төлөвлөгөөний тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 8 | | Иргэд, олон нийтэд хүргэж буй яамны үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааны асуумж бэлтгэн QR код үүсгэн яамны уртах хэсэгт байршуулан, судалгааг жилийн турш авах, үр дүнг удирдлагад танилцуулах. | Судалгааны тайлангийн тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 9 | 1.4.Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ. | Төрийн албан хаагчийн тангарагт ёс зүйг эрхэмлэн сахих талаар тусгаж, өргөсөн тангаргаа чандлан мөрдөх соёлыг хэвшүүлэх зорилгоор мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх; | Бэлтгэн, хүргэсэн мэдээллийн тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 10 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, алдаршуулан олон нийтэд тухай бүрт мэдээлэх; | Олон нийтэд мэдээллийг хүргэсэн эсэх | 0 (Шинээр) | Мэдээллийг тухай бүрт хүргэнэ. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 11 | | Төрийн албан хаагч олон нийтийн санаа бодлыг сонсож, иргэдэд хүндэтгэлтэй хандаж, иргэдийн итгэлийг хүлээхүйц харилцааны болон төрийн албаны нэр хүндэд нийцэхүйц соёлыг | Санал хүсэлтийн хайрцгийг | 0 (Шинээр) | Санал хүсэлтийн хайрцгийг байршуулна. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвшүүлэх зорилгоор санал хүсэлтийн хайрцгийг үгтах хэсэгт байршуулах. | байршуулсан эсэх | | | |
| **Зорилго 2.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх.** | | | | | | |
| 12 | 2.1.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ. | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах; | Сургалтын тоо | 0 (Шинээр) | 5-с доошгүй | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 13 | | Шинээр болон шилжин томилогдсон албан хаагчдад зориулсан “Чиглүүлэх сургалт”-ыг тухай бүрт зохион байгуулах; | Тухай бүрт зохион байгуулсан эсэх | 0 (Шинээр) | Тухай бүрт зохион байгуулна. | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 14 | | Байгууллагын албан хаагчдаас ёс зүйн сургалтад хамруулах; | Сургалтад хамруулсан эсэх | 0 (Шинээр) | Сургалтад хамруулна. | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 15 | | Шинээр болон шилжин томилогдсон албан хаагчдад зориулсан Гарын авлага бэлтгэн, түгээх; | Бэлтгэсэн гарын авлагын тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 16 | | Ёс зүйн хариуцлага хүлээсэн эсхүл сахилгын шийтгэл авсан төрийн албан хаагчийг “Сургагч багш”-ийн ганцаарчилсан сургалтад тухай бүрт хамруулах; | Тухай бүрт хамруулсан эсэх | 0 (Шинээр) | Тухай бүрт хамруулна. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 17 | | Удирдлагын академитай хамтран байгууллагын албан хаагчдад зориулсан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах; | Сургалтын тоо | 0 (Шинээр) | 2-с доошгүй | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 18 | | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах; | Сургалтын тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 19 | | Авлигатай тэмцэх газартай хамтран байгууллагын албан хаагчдад зориулж соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | Түгээсэн контентын тоо | 0 (Шинээр) | 5- с доошгүй | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 20 | | Байгууллагын албан хаагчдад зориулсан ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж зааврааар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг | Батлагдсан хуваарийн тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлэх зорилгоор “Албан хаагчдаа сонсох цаг”-н хуваарийг гарган, батлуулах. | | | | |
| 21 | 2.2.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ. | Байгууллага ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төрлийг тодорхойлж, Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулал, чадавхижуулахтай холбогдох зардлыг байгууллагын төсөвт төсвийг боловсруулан, холбогдох нэгжид хүргүүлэх; | Хүргүүлсэн саналын тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 22 | | Төрийн албаны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг товч, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр албан хаагчдад түгээх, сурталчлах, сургалт зохион байгуулах; | Сургалтын тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 23 | | Төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтран ажиллах. | Хамтран ажилласан эсэх | 0 (Шинээр) | Хамтран ажиллана. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| **Зорилго 3. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах.** | | | | | | |
| 24 | 3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиглэлээр Ёс зүйн дэд хороог бэхжүүлнэ. | Байгууллагын албан хаагчдаас Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгох санал асуулгыг авч, Ёс зүйн дэд хороог байгуулах, Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг батлуулах; | Батлагдсан тушаалын тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны дарга |
| 25 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, баталж, хэрэгжүүлэх; | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 0 (Шинээр) | 1 | Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга |
| 26 | | Ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр Ёс зүйн дэд хороодын гишүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах. | Хамрагдсан гишүүдийн тоо | 0 (Шинээр) | 3-с доошгүй | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 27 | 3.2.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг мэдээлэх тогтолцоог бүрдүүлж, олон нийтийн хяналтыг идэвхжүүлнэ. | Иргэн, албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг тухай бүрт хуваарилах Дэд хорооны гишүүдийн ажлын чиг үүргийг хэрэгжүүлэх; | Чиг үүргийг хэрэгжүүлсэн эсэх | 0 (Шинээр) | Чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Дэд хорооны дарга |
| 28 | | Иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээллийг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлэх; | Шийдвэрлэлтийн хувь | 0 (Шинээр) | 100% | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 29 | | Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн | Тухай бүрт тайлагнасан эсэх | 0 (Шинээр) | Тухай бүрт тайлагнана. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, тайлагнах; | | | | |
| 30 | | Дэд хорооны дүгнэлт, зөвлөмжийг тухай бүрт эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон гомдол гаргасан этгээд, албан хаагчид хүргүүлэх; | Хүргүүлсэн эсэх | 0 (Шинээр) | Тухай бүрт хүргүүлнэ. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 31 | | Гомдол, мэдээлэлд шаардлагатай нотлох баримт, тайлбар, тодруулга авахаар иргэн, төрийн албан хаагч, бусад байгууллагатай тухай бүр харилцах. | Тухай бүр харилцсан эсэх | 0 (Шинээр) | Тухай бүр харилцана. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 32 | 3.3.Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн үнэлгээг чанаржуулна. | Байгууллагын хэмжээнд гарсан ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх; | Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалсан эсэх | 0 (Шинээр) | Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судална. | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 33 | | Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнах, урамшуулах, сургалтад хамруулах асуудлыг шийдвэрлэхэд төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан шударга байх зарчим, шаардлагыг мөрдөх, шударга ажилласан байдал, ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэх байдлыг харгалзан үзэх үйл явцыг бүрдүүлэх; | Үнэлгээний хороонд мэдээллийг хүргүүлсэн эсэх | 0 (Шинээр) | Үнэлгээний хороонд мэдээллийг хүргүүлнэ. | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 34 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон санаачилга, идэвх зүтгэл гарган манлайлсан байдлыг албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох; | Шалгуур үзүүлэлтийн саналыг хүргүүлсэн эсэх | 0 (Шинээр) | Шалгуур үзүүлэлтийн саналыг хүргүүлнэ. | Дэд хорооны нийт бүрэлдэхүүн |
| 35 | | Байгууллага хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргах, Ёс зүйн хороонд хүргүүлэх. | Тайланг нэгтгэн гаргаж, хүргүүлсэн эсэх | 0 (Шинээр) | Тайланг нэгтгэн гаргаж, хүргүүлнэ. | Дэд хорооны нарийн бичгийн дарга |